| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн     | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------------------------|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 29,520,000.00                   | 629,944,759.75        | 254,959,471.26        | 914,424,231.01                          |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | <b>29,520,000.00</b>            | <b>629,944,759.75</b> | <b>254,959,471.26</b> | 914,424,231.01                          |
| C07 | Тайлант үеийн үр дүн                  | -                               | -                     | (21,308,754.08)       | (21,308,754.08)                         |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>29,520,000.00</b>            | <b>629,944,759.75</b> | <b>233,650,717.18</b> | 893,115,476.93                          |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл   | <b>29,520,000.00</b>            | <b>629,944,759.75</b> | <b>233,650,717.18</b> | 893,115,476.93                          |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | <b>29,520,000.00</b>            | <b>629,944,759.75</b> | <b>233,650,717.18</b> | 893,115,476.93                          |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | -                               | -                     | 27,043,231.56         | 27,043,231.56                           |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>29,520,000.00</b>            | <b>629,944,759.75</b> | <b>260,693,948.74</b> | 920,158,708.49                          |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                                  | Тайлант оны           |             |
|-----------------------|-----------------------------------------------------------|-----------------------|-------------|
|                       |                                                           | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл   |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                  | 442,511,200           | 442,524,940 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | 442,511,200           | 442,524,940 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | 442,511,200           | 427,940,028 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | 293,383,200           | 293,382,740 |
| 210101                | Үндсэн цалин                                              | 186,902,000           | 188,326,197 |
| 210102                | Нэмэгдэл                                                  | 83,128,500            | 79,435,448  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 2,402,700             | 3,021,091   |
| 210104                | Урамшуулал                                                | 20,950,000            | 22,600,004  |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | 39,606,700            | 39,606,700  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                        | 27,871,400            | 27,959,000  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                        | 2,933,800             | 2,846,200   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                         | 2,347,100             | 2,347,100   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                      | 586,800               | 586,800     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                     | 5,867,600             | 5,867,600   |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>          | 59,143,700            | 53,417,587  |
| 210301                | Гэрэл, цахилгаан                                          | 3,231,700             | 1,981,373   |
| 210302                | Түлш, халаалт                                             | 42,679,400            | 38,550,300  |
| 210303                | Цэвэр, бохир ус                                           | 13,232,600            | 12,885,914  |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                   | 580,000               | 5,840,700   |
| 210401                | Бичиг хэрэг                                               | 123,000               | 1,211,700   |
| 210402                | Тээвэр, шатахуун                                          | 61,700                | 40,000      |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 101,000               | 190,000     |
| 210404                | Ном, хэвлэл                                               | 70,300                | -           |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | -                     | 60,000      |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 224,000               | 4,339,000   |
| <b>2105</b>           | <b>Нормативт зардал</b>                                   | 45,989,500            | 32,677,300  |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                           | 2,591,900             | 2,658,950   |
| 210502                | Хоол, хүнс                                                | 40,144,900            | 28,973,050  |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                               | 3,252,700             | 1,045,300   |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                  | 1,749,700             | 1,749,700   |
| 210604                | Урсгал засвар                                             | 1,749,700             | 1,749,700   |

|             |                                                                      |             |             |
|-------------|----------------------------------------------------------------------|-------------|-------------|
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | 127,400     | -           |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 127,400     | -           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 575,600     | 565,300     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,600     | -           |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 432,000     | 565,300     |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 1,355,400   | 700,000     |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | -           | 452,000     |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 1,355,400   | 248,000     |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | -           | 14,584,913  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | -           | 13,740      |
| 213202      | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                                 | -           | 13,740      |
| 213         | Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг                           |             | 14,571,173  |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                |             | 14,571,173  |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 442,511,200 | 442,524,940 |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | 381,617,800 | 381,617,800 |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                             | 381,617,800 | 381,617,800 |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | 60,893,400  | 60,893,400  |
| 132001      | Орон нутгийн төсвөөс                                                 | 60,893,400  | 60,893,400  |
| <b>1340</b> | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                  | -           | 13,740      |
| 134001      | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих                                 | -           | 13,740      |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                              | 1           | 1           |
| 610001      | Төсвийн байгууллага                                                  | 1           | 1           |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                              | 27          | 27          |
| 620001      | Удирдах ажилтан                                                      | 1           | 1           |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                                                    | 16          | 16          |
| 620003      | Үйлчлэх ажилтан                                                      | 10          | 10          |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Дансны код  | Үзүүлэлт                                    | Өмнөх он | Гүйцэтгэл            |
|-------------|---------------------------------------------|----------|----------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>    | -        | <b>16,227,600.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                        | -        | <b>16,227,600.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>      | -        | 16,227,600.00        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>     | -        | 16,227,600.00        |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | -        | 16,227,600.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>       | -        | 16,227,600.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>          | -        | 16,227,600.00        |

|        |                                                                                                             |   |               |
|--------|-------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 16,227,600.00 |
|--------|-------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------|

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Д.Алтантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн тооллогыг бодиттой хэрэгжүүлэх, и-баримтыг бүрдлийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз аудитор Ш.Оюунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжих, тэдний хөгжил төлөвшилд гарч буй ахиц амжилтыг чанаржуулан дээшлүүлэх, багшийг мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэхийг үндсэн зорилгоо болгон ажиллажээ.

2020 оны хичээл сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл, баг хамт олны бэлтгэлийг чанар үр дүнтэйгээр зохион байгуулж өдөр тутмын хичээл сургалт, хүүхэд хөгжүүлэлтийг чанарын өндөр түвшинд зохион байгуулж зорилтын дор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагааны үнэлгээг хамтын оролцоотой хийж үр дүнд суурилсан арга зүйг боловсруулах
- Хичээл сургалтын үйл ажиллагаанд багшийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн"Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд ажлын байрандаа хөгжих, чадваржих боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болох, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэн, "Авьяас", "Номын гэгээ", "Хүүхэд бүр цэцэрлэгт" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүүхдийн хөгжлийг дэмжих
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин ажиллах гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"

- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн тус газраас Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 463787,6 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 4637,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21798.5 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын болон үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөг/

| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт          |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|-------------------|
| Б                                                 | 1                  | 2                  | 3=2-1             |
| Авлага                                            | 9,866              | 67                 | (9,799)           |
| Бараа материал                                    | 20,885,398         | 36,688,082         | 15,802,684        |
| Үндсэн хөрөнгө                                    | 872,349,454        | 883,523,059        | 11,173,605        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>893,244,718</b> | <b>920,211,208</b> | <b>26,966,491</b> |
| Өр төлбөр                                         | 129,241            | 52,500             | (76,741)          |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 893,115,477        | 920,158,708        | 27,043,232        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>893,244,718</b> | <b>920,211,208</b> | <b>26,966,491</b> |

Мөнгөн хөрөнгө үлдэгдэлгүй, авлага дансны үлдэгдэл 9,7 мянган төгрөгөөр буурчээ.

Бараа материал данс 15802.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотой ариутгах бодис маск, хамгаалах хувцас зэргийн үлдэгдэл 2658,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон утаанаас хамгаалах зориулалтаар 3955,0 мянган төгрөгийн үнэ бүхий 35 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасан, хүнсний материал 2899,2, эцэг эхийн хандиваар бэлтгэсэн тоглоом бусад эд зүйлсийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11173,6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн элэгдлийн 31250,6 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа боловч аймгийн БСУГ-аас хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлсэн зөөврийн компьютер 2ширхэг, 3499,0,эцэг эхийн хандиваар 990,0 нийт 42424,2 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгажээ.

ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэн 37455.2 мянган төгрөгөөр цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлыг Цаст Оргил констракшн ХХК гүйцэтгэснийг барилгын үнийн дүнг нэмэгдүүлэн бүртгэн тайлагнасан байна.

Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн нийт орлого өмнөх оноос 89201.2 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар өссөн байна.

| Үзүүлэлт                                          | өмнөх оны          | тайлант оны        | Өөрчлөлт          |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|-------------------|
| Б                                                 | 1                  | 2                  | 3=2-1             |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт                  | 319,486,700        | 381,617,800        | 62,131,100        |
| Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт           | 55,542,900         | 60,893,400         | 5,350,500         |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө                | 13,015,302         | 26,196,598         | 13,181,296        |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал         |                    | 5,881,754          | 5,881,754         |
| Хандив бусад тусламж                              | 4,500,000          |                    | (4,500,000)       |
| бусад төвлөрүүлэх шилжүүлэг                       |                    | 16,227,600         | 16,227,600        |
| НДС-аас санхүүжих                                 | 9,084,757          | 13,740             | (9,071,017)       |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>401,629,659</b> | <b>490,830,892</b> | <b>89,201,233</b> |

Өмнөх оны үзүүлэлтээс 2 жижүүр, 1 эмчийн орон тоо нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардал нэмэгдсэн болон Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй холбоотойгоор санхүүжилт нэмэгдэж санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Мөн дээврийн засварын 16227,6 мянган төгрөг байгууллагын харилцах дансаар дамжин гүйцэтгэгчид олгогджээ.

| Үзүүлэлт                           | өмнөх оны          | тайлант оны        | Өөрчлөлт          |
|------------------------------------|--------------------|--------------------|-------------------|
| Б                                  | 1                  | 2                  | 3=2-1             |
| Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ | 263,850,526        | 332,922,498        | 69,071,972        |
| Байр ашиглалттай холбоотой зардал  | 52,381,563         | 53,417,587         | 1,036,024         |
| Хангамж бараа материалын зардал    | 2,898,954          | 1,441,700          | (1,457,254)       |
| нормативт зардал                   | 56,552,112         | 27,155,370         | (29,396,742)      |
| Бусад бараа үйлчилгээний зардал    | 38,134,084         | 21,807,273         | (16,326,811)      |
| бусад урсгал шилжүүлэг             | 9291174            | 27,043,232         | 17,752,058        |
| <b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>           | <b>423,108,413</b> | <b>463,787,660</b> | <b>40,679,247</b> |

Нийт зардал өмнөх оноос 40679,2 мянган төгрөгөөр буюу 9,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 69071,9, бусад урсгал зардал

28392,7 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа 1 сараар хойшилсон, цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 492585.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 492585.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 51073.8 мянган төгрөгөөр бууруулж 442511,2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 442511,2 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 381617,8 орон нутгийн төсвөөс 60893.4 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 381617.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 60893,0 мянган төгрөг, нийт 442511.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 427940.1 мянган төгрөгийг зарцуулж 14571.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар Жаргалант сумын ОНХсангаас цэцэрлэгийн барилгын дээврийн засварт олгосон 16227,6 мянган төгрөгийн санхүүжилт орж зориулалтаараа зарцуулагдсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зардлыг зардлын зүйл анги хооронд гүйлгэн зарцуулж тайлагнасан зөрчлийг засах зөвлөмж өгсөн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 633.5 мянган төгрөгийн цалин, шимтгэлийн тооцооллын зөрүү гарсныг дахин тооцоолж залруулах 3 төрлийн зөвлөмж өглөө.

### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа гараагүй тул залруулга хийгээгүй болно.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэх алдаа зөрчил гараагүй болно.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:**

- а. Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 380.0 мянган төгрөгийн маскиг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **Зардлын данстай холбоотой асуудал.**

- 1.1. **Илрүүлэлт:** ажиллагсдын цалингийн тооцооллыг түүврээр дахин хийхэд 231.3 мянган төгрөгийн илүү, дутуу олгосон, НДШ-н тооцоо 402.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх,
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах,
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

### **2. Анхан шатны баримт бүрдүүлэлт**

- 2.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу
- 2.2 **Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах
- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах
- 2.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна

### **3. Үндсэн хөрөнгийн тооллого**

- 3.1 **Илрүүлэлт:** Жилийн эцсийн тооллогыг эрхлэгчийн тушаалаар баталсан комисс тооллого хийсэн нэх боловч тооллогын бүртгэлд гарын үсэг баталгаажуулаагүй, акталсан хөрөнгө ангилж ялгаагүй агуулахад байсаар байна.
- 3.2 **Эрсдэл:** Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх
- 3.3 **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д заасан анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах
- 3.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|                |                                                                                                                                        |                                      |
|----------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|
| Огноо:<br>2021 | Аудитын нэр:<br><i>Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i> | Аудитын код:<br>ХОАГ-2021/170../СТА- |
|----------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|

|                                                                    |                  |
|--------------------------------------------------------------------|------------------|
| Шалгагдсан байгууллагын нэр:<br>Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэг | Мянган төгрөгөөр |
|--------------------------------------------------------------------|------------------|

| № | Алдаа, зөрчлийн товч утга                                              | Мөнгөн дүн   | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                         |
|---|------------------------------------------------------------------------|--------------|---------------------------------------|---------------------------------------------------|-------------------------|
|   |                                                                        |              | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                |
|   | 1                                                                      | 2            | 3                                     | 4                                                 | 5                       |
| 1 | Ажиллагсад илүү дутуу тооцоолж олгосон.                                | 231.3        | Төлбөрийн акт                         | Эрхлэгч Ня-бо                                     | Д.Алтантуяа<br>Г.Сувдаа |
| 2 | НДШ-н тооцоогоор илүү төлсөн тооцоог дахин тооцоо нийлж баталгаажуулах | 402.2        | Зөвлөмж                               | Эрхлэгч Ня-бо                                     | Д.Алтантуяа<br>Г.Сувдаа |
| 3 | Зарим гүйлгээний и баримтын                                            | 0            | Зөвлөмж                               | Эрхлэгч Ня-бо                                     | Д.Алтантуяа<br>Г.Сувдаа |
| 4 | Эд хариуцагчийн тооцоо тооллогыг актаар баталгаажуулж хэвших           | 0            | Зөвлөмж                               | Эрхлэгч Ня-бо                                     | Д.Алтантуяа<br>Г.Сувдаа |
|   | <b>ДҮН</b>                                                             | <b>633.5</b> |                                       |                                                   |                         |

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР